



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх 86 дугаар журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр “Баруун босоо тэнхлэгийн авто зам барих” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн нийт 1,609,053,679.00 (нэг тэрбум зургаан зуун есөн сая тавин гурван мянга зургаан зуун далан есөн) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг хавсралтад заасан төрийн өмчит авто зам, засвар арчлалтын компаниудын хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хавсралтад заасан авто зам, засвар арчлалтын компанийн Гүйцэтгэх захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 2 дугаар сарын 2 ны өдрийн
219... дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчит авто зам засвар арчлалтын компаниудын үндсэн хөрөнгө бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашиглалта д орсон он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Анхны өртөг (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр) 6098169 1118262983	Хүлээн авах байгууллага
1	Авто ачигч / урдаа шанагтай	2019	ш	1	56,835,650	56,835,650.00	"Багануур -А33А" ТӨХК
2	Авто ачигч	2019	ш	1	63,107,170	63,107,170.00	"Баянчандмань -А33А" ТӨХК
3	Экскаватор	2019	ш	1	130,518,573	130,518,573.00	"Булган -А33А" ТӨХК
4	Авто ачигч / урдаа шанагтай	2019	ш	1	56,835,650	56,835,650.00	"Говь-Алтай -А33А" ТӨХК
5	Авто ачигч / урдаа шанагтай	2019	ш	1	56,815,350	56,815,350.00	"Дархан -А33А" ТӨХК
6	Автогрейдр	2019	ш	1	152,319,542	152,319,542.00	"Завхан- А33А" ТӨХК
7	Автогрейдр	2019	ш	1	152,319,542	152,319,542.00	"Завхан- А33А" ТӨХК
8	Экскаватор	2019	ш	1	130,565,207	130,565,207.00	"Налайх -А33А" ТӨХК
9	Автогрейдр	2019	ш	1	152,265,138	152,265,138.00	"Өвөрхангай- А33А" ТӨХК
10	Экскаватор	2019	ш	1	130,518,573	130,518,573.00	"Талын зам -А33А" ТӨХК
11	Авто ачигч / урдаа шанагтай	2019	ш	1	56,835,650	56,835,650.00	"Төв -А33А" ТӨХК
12	Автогрейдр	2019	ш	1	152,265,138	152,265,138.00	"Харгуй- А33А" ТӨХК
13	Экскаватор	2019	ш	1	130,518,573	130,518,573.00	"Хархорин -А33А" ТӨХК
14	Экскаватор	2019	ш	1	130,518,573	130,518,573.00	"Хөвсгөл -А33А" ТӨХК
15	Авто ачигч / урдаа шанагтай	2019	ш	1	56,815,350	56,815,350.00	"Эрдэнэсант -А33А" ТӨХК
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН					1,609,053,679.00	1,609,053,679.00	
					15 (арван тав)	1,609,053,679.00 (нэг тэрбум зургаан зуун есөн сая тавин гурван мянга зургаан зуун далан есөн)	